

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2023 он

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль							
1	10	8	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай 2011-02-02 Дугаар 2011.02.02	19.1.9. Төрийн захиргааны төв байгууллага жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайлан, Жендэрийн үндэсний хороонд дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх. - Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн 2022 оны мэдээг ЖҮХ-ны мэргэжилтэнд 2023.01.03-ны өдөр мэйлээр хүргэгдсэн. - Албаны албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын жилийн мэдээ УУХҮЯ-нд хүргэгдсэн. - 2023.06.20-нд болсон "Олборлох салбарын жендэрийн талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний эхэн үеийн хэрэгжилтийн тайланд хийсэн үнэлгээний дагуу цаашдын төлөвлөлтөд зөвлөмж дүгнэлт өгөх семинар"-т 1, 2023.09.30-нд болсон "Ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ" цахим сургалтад 5, 2023.11.01-нд болсон "Жендэрийн мэдрэмжтэй харилцаа, холбоо цахим сургалт"-д 1 албан хаагч хамрагдсан. - Жендэрийн үндэсний хорооноос 2023.03.23, 24-нд зохион байгуулсан "Жендэрийн үндэсний сургагч багш бэлтгэх" сургалтад хамрагдсан.	100%		Үндэсний гелогийн алба

					- 2023.04.11-нд "Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт" үндэсний форумд оролцсон. - Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх Монгол Улсын Засгийн Газрын тайланд тусгах мэдээллийг 2023.08.01-ний өдрийн 1/401 дугаартай албан бичгээр УУХҮЯ-нд хүргүүлсэн. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Хүйсийн 60:40 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах" талаар заасан ба манай байгууллага эрэгтэй албан хаагч 10, эмэгтэй албан хаагч 20 буюу 67:33 гэсэн хүйсийн харьцаатай ажиллаж байна. Тайланг ирэх оны 2 дугаар сард хүргүүлнэ.			
2	11	16	Төрийн албаны тухай хууль 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	2023 оны сургалтын төлөвлөгөөг нэгжүүдийн хэрэгцээ шаардлага саналыг үндэслэн боловсруулсан ба, албаны даргаар батлагдсан. Сургалтын төлөвлөгөөний дагуу Хувь хүний хөгжил, манлайллын чиглэлээр 4 төслийн 6 сургалт, төрийн болон хувийн байгууллагын 8 сургалт, ТАЗ-өөс зохион байгуулсан 7 сургалт, мэргэшүүлэх чиглэлээр 5 байгууллагаас зохион байгуулсан 13 сургалт, Удирдлагын академийн Төрийн албан хаагчийн 4 багц сургалт гэх мэт нийт 38 төрлийн сургалтад давхардсан тоогоор 256 албан хаагч хамрагдсан. Үүнд: Танхимаар: • BGR төслийн 2023.04.13-21-нд зохион байгуулсан сургалтад 6, • Амеп төслийн 2023.05.02-нд зохион байгуулсан сургалтад 2,	100%		Үндэсний геологийн алба

				• ССОР төслийн 2023.09.13-15-нд зохион байгуулсан сургалтад 6, • Япон геологийн албаны 2023.01.17-31-нд зохион байгуулсан сургалтад 1, • Монголын геологийн холбоо 2023.04.23-нд зохион байгуулсан сургалтад 1, • Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И-Монгол академи, АЕГазар 2023.05.23, 24-нд зохион байгуулсан сургалтад 1, • ШУТИС, УГА, "ГСШТ" ТӨҮГ 2023.05.02-нд зохион байгуулсан сургалтад 2, • АТГазар 2023.09.29-нд зохион байгуулсан сургалтад 1 албан хаагч гэх мэтээр тус тус хамрагдсан. Цахимаар ТАЗ-ийн: • 2023.02.02-нд зохион байгуулсан сургалтад 20, • 2023.03.02-нд зохион байгуулсан сургалтад 15, • 2023.04.06-нд зохион байгуулсан сургалтад 12, • 2023.10.19-нд зохион байгуулсан сургалтад 14, • 2023.11.02-нд зохион байгуулсан сургалтад 20, • 2023.11.09-нд зохион байгуулсан сургалтад 21 • 2023.11.30-нд зохион байгуулсан сургалтад 11 албан хаагч тус тус хамрагдав. Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн - Ахлах түшмэлийн багц сургалтад 2, - Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2,			
--	--	--	--	---	--	--	--

					-Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3, - Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдсан. -Гэр хороололд амьдарч буй албан хаагчдын түлээ, нүүрсний мөнгийг албан хаагчдад жил бүр олгов.			
3	77	116	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_203	1. 1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 1.2.	2023 оны байдлаар төрийн хэмнэлтийн тухай хууль үргэлжлэн хэрэгжиж, Дэд даргын ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийг холбогдох албан тушаалтнуудад хуваарилан гүйцэтгүүлж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/1762 тоот албан бичгийн дагуу тус байгууллагын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөл, цахим дэлгүүрт оруулах бараа үйлчилгээний тоо, хэмжээ, гэрээ байгуулах нэгж, үнийн талаарх санал мэдээллийг боловсруулж, 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 1/373 тоот албан бичгээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн ба батлагдсан. -Тус байгууллагын 2023-2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөлөл боловсруулахтай холбогдуулан хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад хориглосон арга хэмжээг тусгаагүй болно.	100%		Үндэсний геологийн алба

				жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах;	-Албаны үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулсан.			
4	78	118	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204	1. Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого,	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тус байгууллагын эзэмшилд байдаг тээврийн хэрэгслүүдийн тухай мэдээллийг -2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 1/284, -2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 3/364 тоот албан бичгээр хүргүүлсэн. Тус алба нь улсын төсвийн санхүүжилтээр Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамран гүйцэтгэж буй геологи судалгаа, эрэл, эрэл-үнэлгээний ажлын хээрийн шуурхай хяналтыг зохион байгуулах чиг үүргийн дагуу 2022 оны улсын төсвийн санхүүжилтийг төсөл бүрээр тулган	100%		Үндэсний геологийн алба

				зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	шалгах зорилготой геологи судалгаа, эрэл, эрэл үнэлгээний нийт 60 гаруй төслийн гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах ажлыг гүйцэтгэхэд тус албанд бүртгэлтэй Тоёота ландкрузер маркийн УАК 5863 дугаартай автомашиныг батлагдсан хуваарийг дуусталх хугацаанд түр ашиглах зөвшөөрөл хүссэн 2022 оны 07 дугаар сарын 22-ны 1/418 тоот албан бичгийг тус тус ТӨБЗГ-т хүргүүлж ажиллав. ҮГА Засгийн газрын автобаазтай 2020 оноос өнөөг хүртэлх хугацаанд “Автомашинаар үйлчилгээ үзүүлэх” гэрээ байгуулж, хээрийн шуурхай хяналт хийж гүйцэтгэж байгаа болно. Мөн хуулийн 8,9,11,12,15 дугаар зүйлүүдэд заасан холбогдох, хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй болно.			
УИХ-ын тогтоол шийдвэр								
5			2023 оны 06 дугаар сарын 30-ны УИХ-ын тогтоол	Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр	Авилгатай тэмцэх газраас өгсөн чиглэлийн дагуу Үндэсний геологийн албаны төрийн захиргааны албан хаагчдын ХАСХОМ хүлээн авсан бүртгэл, ХАСУМ бүртгэл, мэдэгдэл, тайлбар, Үндэсний геологийн албаны зохион байгуулалтын бүтцийн ерөнхий бүдүүвч, Албаны Стратеги зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт үндэслэн ХАСХОМ бүрдүүлэх гаргавал зохих албан хаагчид, 2022 оны ХАСХОМ мэдүүлэх	100%		Үндэсний геологийн алба

					үүрэгтэй мэдүүлэг гаргачдын жагсаалтыг гаргасан. Нийт мэдээллийг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 1/02 дугаар албан бичгээр хүргүүлсэн. ХАСХОМ гаргавал зохих 19 төрийн захиргааны албан хаагч байхаас 2 сул ажлын байр нөхөгдөөгүй тул 17 албан хаагчийн ХАСХОМ-ыг шаардлагатай засвар, өөрчлөлтийг хийлгүүлэн, хуулийн хугацаанд баталгаажуулах ажлыг гүйцэтгэсэн. Тайлант хугацаанд хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлт гараагүй. Шинээр томилогдох болон ажил хавсран гүйцэтгэхтэй холбоотой 6 албан хаагчийн ХАСУМ эрх нээх хүсэлтийг хүргүүлж шийдвэрлүүлсэн. Үндэсний геологийн албаны албан хаагчдын 2022 оны ХАСХОМ тайлан мэдээг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 2/126 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үүнд: • Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн 2022 оны тайлан; • Албан тушаалтны 2022 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй мэдээлэл; • Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэл; • Албан тушаалтнуудын 2022 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн хураангуй мэдээлэл. Албан хаагчдын 2022 оны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэл.			
--	--	--	--	--	--	--	--	--

					Хүрсэн түвшин: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж ажиллав.			
Засгийн газрын тэмдэглэл								
6	124		2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл 2022-02-23 Дугаар 2022_12	Х.5. 2023 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд	2023 онд Үндэсний геологийн албанд 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл гомдлын сайтад 2 гомдол ирснийг шийдвэрлэсэн байна. Үүнд: 1. Автомашины зогсоол ашиглах тухай гомдол 2. Геологийн судалгаа, шинжилгээний төвийн 1 албан хаагч хууль бусаар ажлаас халсан тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ирүүлсэн гомдлыг 100% шийдвэрлэсэн.	100%		Үндэсний геологийн алба

				судлан иргэнд заавал хариу өгч байх				
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам								
7	-		2023 оны 03 дугаар сарын 28-ны А/78 дугаар	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын Төрийн захиргааны албан хаагчдын томилгоотой холбоотой шалгалт хийх тухай ажлын хэсэг	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 28-ны А/78 дугаар тушаалаар Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 03 дугаар сарын ХЭГ/595 дугаар албан бичгээр ирүүлсэн шалгалт хийх чиглэлийн дагуу Үндэсний геологийн албаны Төрийн захиргааны албан хаагчдыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох журмын дагуу албан ёсоор томилогдсон эсэхэд хяналт шалгалт хийгдсэн. Танилцуулсан материал: -Төрийн албан хаагч бүрийн анкет -2022, 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, үнэлгээний хуудсууд баталгаажсан эсэх талаарх мэдээлэл хяналт шалгалтын ажлын хэсэгт цаасаар танилцуулсан. Шалгалтын үр дүнг хүлээн авсан ба ямар нэг зөрчил дутагдал илрээгүй.	100%		Үндэсний геологийн алба
8			2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 06-00-008 дугаар	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийх” ажлын хэсэг	Геологийн судалгааны төслүүдийн геологийн даалгавар, захиалагчтай байгуулсан 2019-2022 оны гэрээ, 2019-2023 оны төсвийн тодотгол, 2019-2023 оны гүйцэтгэлийн баримт, 2022 онд хамгаалагдах 22 төслийн явц, гэрээ дүгнэсэн акт, хээрийн материал хүлээн авсан акт, нормчлол, санхүүжилт хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт зэрэг бусад шаардлагатай мэдээллийг бэлтгэж өгөх, тайлбаруудыг хийсэн.	100%		Үндэсний геологийн алба

					Агентлагийн хэрэгжүүлж буй хөтөлбөр, тайлан, үнэлгээний асуудлаар: Агентлагийн Стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр -Стратеги төлөвлөгөө 2020-2024 -Төсвийн шууд захирагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө -Төсвийн шууд захирагчийн 2022, 2023 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайлан Нийт албан хаагчдын 2022, 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө 2022, 2023 оны хагас, бүтэн жилийн албан хаагчдын тайлан, үнэлгээний хуудас -Хүний нөөцийн асуудлаарх мэдээллүүдийг танилцуулсан. Өнөөдрийн байдлаар шалгалтаар зөрчил дутагдлын талаар ямар нэг баримт ирээгүй байгаа болно.			
				Дундаж		100,0%		

Танилцсан: Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Мөнхтөр

Хянасан: ТЗУХ-ийн дарга

С.Шинэ-Од

Бэлтгэсэн: ТЗУХ-ийн мэргэжилтэн

Б.Мөнхтуяа

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:
Дотоод хяналт шинжилгээ үнэлгээ
хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхтуяа
Холбоо барих утас: 70181208
Цахим шуудан: b.munkhtuya@ngs.gov.mn